



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/153

Алтай хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/116 дугаартай Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн спорт заалны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын үнэлгээний хорооны захирамжийн 1 дүгээр хэсэгт “Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн” гэснийг “Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн” мөн “Үнэлгээний хорооны гишүүн: Б.Батбаатар -Есөнбулаг сумын иргэн” гэснийг “П.Буян-Өлзий -Есөнбулаг сумын иргэн”, “Б.Жигжээ -Төрийн бус байгууллагын төлөөлөл” гэснийг “Г.Ундрам -Төрийн бус байгууллагын төлөөлөл” болгон тус тус өөрчилсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Д.Баттайван)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

